



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/41

Мөрөн сум

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл
ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга
хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийж батлах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.1.1, 19.4, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний тодотголыг 1 дүгээр, “Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-г 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг жил бүрийн Улсын болон аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улс, орон нутгийн төсвийн төсөлд тусган хэрэгжүүлж, ажиллахыг хэлтэс, агентлаг, байгууллагын удирдлагууд, сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Хариуцсан салбарын хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн тайланг жил бүр аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нарт даалгасугай.

4. Батлагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг жил бүр аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/179 захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН